

## Говь-Алтай аймгийн Аудитын газар



Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

### ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АРВАН САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ МЭДЭЭЛЭЭГҮЙ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД БҮХ ШАТНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ ХЯНАЛТ ТАВИАГҮЙГ ЭС ТООЦВОЛ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖИЖ БАЙНА.

Алтай хот

2015 он

## Агуулга

### Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймгийн  
Аудитын газрын  
лil баг

Дарга, Тэргүүлэх аудитор  
Х.Түвшинбаяр  
Утас: 99489309

Аудитын менежер  
Д.Эрдэнэчимэг  
Утас: 99175677

Ахлах аудитор  
Д.Цэрэнханд  
Утас:99147999

Аудитор:  
Г.Цэцэгмаа  
Утас:99489399

Шинжээч:  
Ц.Сайханжаргал  
Утас: 88665099

2015 оны 11 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70483413, 70484055  
дугаарын утас, 70484030  
дугаарын факсаар  
харилцана уу.

Хаяг:  
Говь-Алтай аймаг  
Есөнбулаг сум  
Баянхайрхан баг

|                                                          |   |
|----------------------------------------------------------|---|
| Товчилсон үгсийн жагсаалт.....                           | 2 |
| Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй..... | 3 |
| Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....  | 4 |
| Үндсэн мэдээлэл.....                                     | 5 |

### Нэг: ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.4-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХГҮЙ БАЙНА.

- 1.1 Хуулийн 3.1.1-д заасан 4 байгууллагаас бусад байгууллага нь хамрагдсан байна.
- 1.2 Хуулийн 3.1.2-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байна.
- 1.2 Манай аймагт хуулийн 3.1.3-т заасан байгууллага байхгүй тул аудитад хамрагдсангүй.
- 1.3 Хуулийн 3.1.4-т заасан хуулийн этгээд нэгдсэн цахим хуудсанд хамрагдах боломжгүй байна.
- 1.4 Хуулийн 3.1.5-д заасан байгууллага байхгүй тул аудитад хамрагдсангүй

### Хоёр: ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ЗАРИМ МЭДЭЭЛЛИЙГ ОГТ ОРУУЛААГҮЙ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ИЛҮҮ, ДУТУУ МЭДЭЭЛЖЭЭ.

- 2.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус, зарим мэдээллийг огт мэдээлээгүй, зөрүүтэй, илүү, дутуу мэдээлсэн байна
- 2.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлсэн эсэхийг нотлох боломжгүй, мэдээллийг дутуу, зөрүүтэй мэдээлжээ.
- 2.3 Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Сангийн яам бөгөөд энэ асуудлыг ҮАГ дээр авч үзнэ
- 2.4 Төрийн захиргааны байгууллагууд НДС-гаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг 57%-тай мэдээлжээ
- 2.5 Хуулийн 3.1.3-т заасан байгууллага байхгүй
- 2.6 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан байгууллагууд 6.9-д заасан мэдээллийг мэдээлээгүй байна.

### Гурав: БҮХ ШАТНЫ ИТХ, БИНХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХГҮЙ БАЙНА.

- 3.1 Бүх шатны ИТХ, БИНХ-аас шилэн дансны үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- 3.2 Санхүүгийн хяналт, аудитын алба нь шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж ажиллаж байна.
- 3.3 Өмнөх шийдвэрийн хэрэгжилт 43 хувьтай байна.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| ЗГ           | Засгийн газар                                                                             |
|--------------|-------------------------------------------------------------------------------------------|
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ХААА         | Худалдан авах ажиллагааны алба                                                            |
| ХАА          | Худалдан авах ажиллагаа                                                                   |
| МХГ          | Мэргэжлийн хяналтын газар                                                                 |
| ХБХ          | Хөгжлийн бодлогын хэлтэс                                                                  |
| ЗДТГ         | Засаг даргын тамгын газар                                                                 |
| ЗД           | Засаг дарга                                                                               |
| ТӨҮГ         | Төрийн өмчит үйлдвэрийн газар                                                             |
| ТӨХК         | Төрийн өмчит хувьцаат компани                                                             |
| ОНХС         | Орон нутгийн хөгжлийн сан                                                                 |
| СХС          | Сум хөгжүүлэх сан                                                                         |
| БХНСС        | Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан                                                       |
| ИТХ          | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                                                              |
| БИНХ         | Багийн иргэдийн нийтийн хурал                                                             |
| НДХ          | Нийгмийн даатгалын хэлтэс                                                                 |
| НДС          | Нийгмийн даатгалын сан                                                                    |
| ХХК          | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                                      |
| ОНХО         | Орон нутгийн хөрөнгө оруулалт                                                             |
| ЕБ           | Есөнбулаг                                                                                 |
| УАУТ         | Уламжлалт анагаах ухааны төв                                                              |
| УБХ          | Улсын бүртгэлийн хэлтэс                                                                   |
| ТЕЗ          | Төсвийн ерөнхийлөн захирагч                                                               |
| ОНӨААТҮГ     | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                      |
| ОНӨҮГ        | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар                                                       |
| ЕБС          | Ерөнхий боловсролын сургууль                                                              |
| ГАА          | Говь Алтай аймаг                                                                          |
| АЗЗА         | Авто замын засвар арчлалт                                                                 |
| ЖДҮДТ        | Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв                                                          |

## **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн бүрэн эрхийн хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийлээ.

## **Аудитын зорилт**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх
2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх
3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх
4. Иргэдийн хяналт ба өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

## **Аудитын хамрах хүрээ**

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд байгууллага, албан тушаалтан хамрагдах бөгөөд дараах баримт материалыг хамаарна.

- Шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт тавьсан мэдээллүүд
- Байгууллагуудын сар бүрийн төрийн сангийн харилцах дансны хуулга, төлбөрийн хүсэлт /2015 оны 09 сарын 30-ны байдлаар/
- Байгууллагын 2014 оны болон 2015 оны хагас жилийн санхүүгийн тайлан
- Аудитын дүгнэлт, шийдвэр, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ажлын тайлан /2015 он/
- Байгууллагын батлагдсан орон тоо, төсөв /өөрчлөлт орсон тухай бүрд/
- Байгууллагын даргын тушаал /өр авлага, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр/
- ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын тендер шалгаруулалтын мэдээлэл, санхүүжүүлсэн байдал
- СХС, БХНСС-гийн 2015 оны дансны хуулга
- Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 2014 онд хийгдэх автозамын засвар, шинэчлэлтийн ажлын жагсаалт
- НДС-гаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн судалгаа
- Иргэд, сумын ИТХ, БИНХ-ын шилэн дансны цахим хуудсанд хяналт шалгалт хийсэн материалууд, өгсөн үүрэг даалгавар, түүний биелэлт
- Аудитын газраас аудит хийсэн шийдвэрийн хэрэгжилт
- 10.0 сая төгрөгөөс дээш төсөл арга хэмжээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа ААН, иргэдийн бүлгийн цахим хуудсанд тавьсан мэдээлэл

## **Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, зорилго**

Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх

шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

### **Аудитын стандартын талаархи мэдэгдэл**

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгоно.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 384-р тушаал “Журам батлах тухай”

### **Аудит ашигласан арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дэд хөтөлбөр боловсруулан дараах арга зүйг ашиглалаа.

- Холбогдох байгууллагуудын жилийн батлагдсан төсөв, тодотгосон төсвийг шилэн дансанд мэдээлсэн төсөвтэй тулган баталгаажуулсан
- Тухайн онд тендер зарласан, ХАА явуулсан баримт бичгийг шилэн данс мэдээллийн самбарт мэдээлсэн мэдээлэлтэй тулган баталгаажуулсан
- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тухайн онд хүрэх түвшингийн үзүүлэлттэй танилцан, мэдээлсэн эсэхийг тулагн үзсэн
- Дансны хуулгыг авч, төсвийн гүйцэтгэлийн дүнг 6 сарын 30, 09 сарын 30-ны байдлаар үнэн зөв мэдээлсэн эсэхийг анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулж, холбогдох албан тушаалтнаар гарын үсэг зуруулж хүлээн зөвшөөрүүлсэн
- Байгууллагын өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэхтэй холбоотой шийдвэрүүдтэй танилцан, мэдээлсэн эсэхийг тулган баталгаажуулсан
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх тушаал шийдвэртэй танилцан, мэдээлсэн эсэхийг үзсэн.
- Холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, шилэн дансны тухай хууль, цахим мэдээлэлийн сангийн талаар санал авсан
- Шилэн дансны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш авч хэрэгжүүлсэн төлөвлөгөөт ажилууд, хяналт шалгалтын материалуудтай танилцсан
- Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг газар дээр нь үзсэн зэрэг аудитын горимуудыг ашиглана

### **Үндсэн мэдээлэл:**

*Шилэн дансны тухай хууль* 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн байна. ҮАГ-аас 5 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитад 5804 байгууллага хамрагдсан ба аудитын дүн дүгнэлтэд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар МУ-ын Ерөнхий сайдад ЗГ-ын хэрэг эрхлэх газар, Сангийн яамны “*Шилэн дансны тухай хуулийн*” хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгт анхаарлаа хандуулж, нэгдсэн арга зүйгээр хангах, хяналтын асуудлыг шийдвэрлэх, аймаг сумдын төсвийн болон төрийн байгууллагын ажилтнууд, Шилэн дансны тухай хуулийг сурталчлах ажлыг эрчимжүүлж байна.

Аймгийн хэмжээнд хуулийн 3.1.1-д заасан 196 байгууллага 3.1.2-т заасан 3 байгууллага, 3.1.3, 3.1.5-д заасан байгууллага байхгүй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар аудит хийх бүртээ дэд асуудал болгон авч үзэж тайланд оруулан шийдвэр гаргаж байна.

## **БҮЛЭГ 1. ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1.4-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХГҮЙ БАЙНА.**

### **1.1 Хуулийн 3.1.1-д заасан 4 байгууллагаас бусад байгууллага нь хамрагдсан байна.**

Шилэн дансны тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамрагдах 196 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрээс 4 хуулийн этгээд нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нэр нь ороогүй, мэдээллээ тавиагүй байна. Үүнд Дарив сумын “Дулаан” ОНӨААТҮГ, Эрдэнэ сумын “Эрчим хүч” ОНӨААТҮГ, Тагнуулын хэлтэс, Автотээврийн үндэсний төвийн Говь-Алтай аймаг дахь салбар байна.

**Хүснэгт №1: Хуулийн 3.1.1-д заасан байгууллагууд, тэдгээрийн шилэн дансанд оруулсан судалгаа**

| 3.1.1-д заасан байгууллагууд                          |     | 3.1.1-д заасан цахимд орсон байгууллагууд                                              |     |
|-------------------------------------------------------|-----|----------------------------------------------------------------------------------------|-----|
| Шилэн дансанд орох нийт байгууллагын тоо              | 196 | Шилэн дансанд орсон нийт байгууллагын тоо                                              | 216 |
| Үүнээс: Нэр нь ороогүй байгууллагын тоо               | 4   | Үүнээс: Нэр нь илүү орсон байгууллага, сан, бусад                                      | 13  |
| Үүнээс: Нэр нь орсон байгууллагын тоо                 | 192 | Үүнээс: Нэр давхардсан                                                                 | 4   |
| Шилэн дансны хуулийн хүрээнд хамрагдах хуулийн этгээд | 192 | Шилэн дансны хуулийн хүрээнд хамрагдаж байгаа хуулийн этгээд /Үүний дотор 3 сан орсон/ | 199 |

Шилэн дансны цахим хуудсанд нийт 216 байгууллага орсноос 3 нь ТӨҮГ бөгөөд 213 байгууллага, төсөл сан, хөтөлбөрийн нэр цахим хуудсанд үүсгэгдсэн байна. Үүнээс:

- Нэр нь илүү орсон: Сумдын ЕБС, Сумдын цэцэрлэг, ГАА Засаг дарга, Баян-Уул сумын ОНХС, Дэлгэр сумын ОНХС, Халиун сумын ОНХС, Чандмань сумын ОНХС, Баян-Уул сумын орон нутгийн ерөнхий орлого, Жаргалант Засаг даргын нөөц, Баян-Уул сумын СХС, Алдарт эх одон, Алдар цолтой ахмад хөнгөлөлт, Хөгжилтэй Андууд гэсэн нэрээр орсон байна.
- Нэр нь давхардсан: Улсын бүртгэлийн хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Монгол элсний тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, Алтай чуулга зэрэг байгууллагууд байна.

### **1.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан байгууллагууд хуулийн үйлчлэлд бүрэн хамрагдаж байна.**

Манай аймгийн тухайд Орон нутгийн Нисэх буудал ТӨҮГ, “АЗЗА” ТӨҮГ, Радио өргөн нэвтрүүлэх станц ТӨҮГ зэрэг 3 төрийн өмчит үйлдвэрийн газар байна. Эдгээр нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд өөрийн нэрээр цэстэй, хуулийн үйлчлэлд бүрэн хамрагдаж байна.

### **1.3 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани аймагт байхгүй болно.**



**1.4 Төсвийн хөрөнгөөр ажил үйлчилгээ, гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах боломжгүйгээс хуулийн үйлчлэлд хамрагдаж чадахгүй байна.**

Шилэн дансны тухай хуулийн 5.4<sup>1</sup> дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баталжээ.

Хууль, журамд зааснаар 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгж, хуулийн этгээд нь хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийг олон нийтийн цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно гэж заажээ.

Аймгийн хэмжээнд 10.0 сая төгрөгөөс дээш төсөл арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа давхардсан тоогоор 121 аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн бүлэг байна.

**Хүснэгт №2: 10.0 сая төгрөгөөс дээш төсөл арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААН**

| Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААН, байгууллага | Тоо        |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| А. Аж ахуй нэгж байгууллага, компани                                                                                                  | 76         |
| Б. Төрийн бус байгууллага                                                                                                             | 1          |
| В. Мэргэжлийн холбоодын нэр                                                                                                           | 0          |
| Г. Олон нийтийн байгууллагын нэр                                                                                                      | 0          |
| Д. Хоршоо, нэгдэл, иргэдийн бүлэг                                                                                                     | 44         |
| <b>Нийт дүн</b>                                                                                                                       | <b>121</b> |

Дээрх байгууллагууд нь санхүүжилт авсан төсвийн байгууллагын нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл огт тавиагүй, тавих цэс тодорхой бус, энэ талаарх мэдээллийг тавьсан эсэхийг хянадаг, шаарддаг албан тушаалтнуудыг тодорхой зааж өгөөгүйгээс хуулийн үйлчлэлд бүрэн хамрагдаж чадахгүй байна.

**1.5 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага байхгүй байлаа.**

<sup>1</sup> Энэ хуулийн 5.1, 5.3-т заасан цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам, хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

**БҮЛЭГ 2. ХУУЛИЙН 3 ДУГААР ЗҮЙЛИЙН 3.1-Д ЗААСАН БАЙГУУЛЛАГУУД 6 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ЗАРИМ МЭДЭЭЛЛИЙГ ОГТ ОРУУЛААГҮЙ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ИЛҮҮ, ДУТУУ МЭДЭЭЛЖЭЭ.**

**2.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус, зарим мэдээллийг огт мэдээлээгүй, зөрүүтэй, илүү, дутуу мэдээлсэн байна.**

Шилэн дансны тухай хууль, журамд зааснаар тогтсон хугацаанд тайлагнах мэдээллийг тоогоор болон чанарын үзүүлэлт, файлаар оруулахаар баталж өгсөн.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ТӨҮГ-уудын 9 сарын 30-ны байдлаар дансны хуулгыг авч шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1<sup>2</sup>, 4.1.2<sup>3</sup>, 4.1.3<sup>4</sup> дахь заалтыг зөрчин тухайн жилийн төсвийг 1,481.9 сая төгрөгөөр дутуу, 28.5 сая төгрөгөөр илүү мэдээлсэн, төсвийн гүйцэтгэлийг 3-р улирлын байдлаар 834.2 сая төгрөгөөр дутуу, 504.0 сая төгрөгөөр тус тус илүү мэдээлжээ.

**Хүснэгт №3: Хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан мэдээлэлийг мэдээлсэн байдал /сая.төг/**

| Хуулийн этгээдийн төрөл                                     | Тухайн жилийн төсөв, төлөвлөгөө /сая.төг/ |                 |                 |                | Гүйцэтгэл /9.30-ны байдлаар/сая.төг/ |                 |                 |                |
|-------------------------------------------------------------|-------------------------------------------|-----------------|-----------------|----------------|--------------------------------------|-----------------|-----------------|----------------|
|                                                             | Мэдээлэх дүн                              | Мэдээлсэн дүн   | Мэдээлээгүй дүн | Илүү мэдээлсэн | Мэдээлэх дүн                         | Мэдээлсэн       | Мэдээлээгүй дүн | Илүү мэдээлсэн |
| <b>3.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд</b> | 67,460.8                                  | 66,007.3        | 1,481.9         | -28.5          | 44,157.5                             | 43,901.3        | 834.2           | -504.0         |
| А. Төрийн өмчит хуулийн этгээд                              | 56,136.7                                  | 55,674.3        | 473.7           | -11.3          | 37,000.3                             | 36,938.7        | 597.3           | -459.1         |
| Б. Орон нутгийн өмчит хуулийн этгээд                        | 9,349.0                                   | 9,104.0         | 262.2           | -17.2          | 6,354.0                              | 6,242.5         | 156.5           | -45.0          |
| В. ОНӨААТҮГ, ОНӨҮГ                                          | 1,975.1                                   | 1,229.1         | 746.0           | 0              | 800.5                                | 720.1           | 80.4            | 0              |
| <b>3.1.2 Төрийн өмчит үйлдвэрийн газар</b>                  | 1,484.0                                   | 1,484.0         | 0               | 0              | 772.6                                | 772.6           | 0               | 0              |
| <b>ДҮН</b>                                                  | <b>68,944.8</b>                           | <b>67,491.3</b> | <b>1,481.9</b>  | <b>-28.5</b>   | <b>44,930.1</b>                      | <b>44,673.9</b> | <b>834.2</b>    | <b>-504.0</b>  |

Сум, аймгийн ОНХС-гийн төлөвлөгөө 7,159.9 сая төгрөг батлагдсанаас 5,118.3 сая төгрөгийн төлөвлөгөөг мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус, 2,041.6 сая төгрөгийн ажлуудын төлөвлөгөөг огт мэдээлээгүй байна. ОНХС-гийн гүйцэтгэл 3-р улирлын байдлаар 3,956.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гарснаас 3,680.1 сая төгрөгийг мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус, 769.0 сая төгрөгийн гүйлгээг орхигдуулсан, 492.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг илүү мэдээлсэн байна. /хавсралт №1/

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 18 байгууллага мэдээлэхээс 8 байгууллага мэдээлж, 10 байгууллага мэдээлээгүй байна. /хавсралт №1/

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 199 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ТӨҮГ-ууд нь 6.1.3-6.1.6-д заасан бусад мэдээллийг дараах байдлаар мэдээлжээ. /Хавсралт №2 /

- 6.1.3-т заасан 2016 оны төсвийн төсөл: ТӨҮГ болон ОНӨААТҮГ-уудын төсвийн төсөл батлагдаагүй-5, төсвийн төслөө хугацаандаа мэдээлсэн-24, мэдээлсэн боловч хугацаа нь тодорхой бус-92, мэдээлээгүй-74 байгууллага байна.

2 Мэдээлэл, үнэн зөв, бодитой, иж бүрэн байх

3 Мэдээлэл ойлголцмжтой ач холбогдолтой байх

4 тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх



- 6.1.4-т заасан Санхүүгийн тайлан /2014 оны жилийн эцсийн/: Хугацаандаа мэдээлсэн-17, мэдээлсэн боловч хугацаа нь тодорхой бус-133, хугацаа хоцорч мэдээлсэн-8, мэдээлээгүй-37 байгууллага байна.  
Санхүүгийн тайлан /2015 оны хагас жил/: Хугацаандаа мэдээлсэн-17, мэдээлсэн боловч хугацаа нь тодорхой бус-119, хугацаа хоцорч мэдээлсэн-8, мэдээлээгүй-51 байгууллага байна.
- 6.1.5-д заасан ТЕЗ-ийн төсвийн багцад хийсэн аудитын тайлан: Хугацаандаа мэдээлсэн-17, мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус-141, мэдээлээгүй-37 байгууллага байна. Аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хугацаандаа мэдээлсэн-17, мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус-91, огт мэдээлээгүй-87 байгууллага байна.
- 6.1.6-д заасан Төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбар: Байгууллагуудын 3-р улирлын байдлаарх төсвийн гүйцэтгэлийн хэтэрсэн хэмнэсэн зардлын дүн 3,494.2 сая төгрөг байна. Үүнээс 1,385.2 сая төгрөгийн хэмнэсэн зардлын тайлбар оновчгүй, зарим байгууллага огт тайлбар бичээгүй байна.

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг мэдээлсэн 6 сум, 3 байгууллага байна.  
Тухайлбал: Гуулин тосгон, Тайшир, Халиун, Шарга, Хөхморьт, Чандмань сумууд, УБХ, Татварын хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн төв, г.м

Хуульд зааснаар шилэн дансны цахим нэгдсэн санд сумдын СХС, БХНСС тусгай сангуудын орлого, зарлагын гүйцэтгэл, аудитын тайлан дүгнэлт, санхүүгийн тайлан, төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг мэдээллүүдийг ямар цэсэнд ямар хугацаанд оруулахыг тодорхой зааж өгөөгүйгээс ихэнх байгууллагууд цэсийг харгалзан үзэлгүйгээр дуртай цэсэндээ мэдээллийг оруулсан байна.

Харин Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4 дэх заалтуудыг мэдээлэх албан тушаалтныг хууль, журамд тодорхой зааж өгчээ.

## **2.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлсэн эсэхийг нотлох боломжгүй, мэдээллийг дутуу, зөрүүтэй мэдээлжээ.**

Шилэн дансны тухай хуулийн 6.4 –т заасан мэдээллүүдийг мэдээлсэн эсэхийг үзэхэд дараах байдалтай байна. /хавсралт№3/

- 6.4.1-д заасан тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт: Нийт 151 байгууллагын төсөв өөрчлөгдсөн бөгөөд түүнээс 25 байгууллага төсөвт орсон өөрчлөлтийг мэдээлээгүй байна. Тухайлбал: Жаргалан сумын ИТХ, ЗДТГ, Дунд сургууль, Баян-Уул сумын сургууль, Бигэр сумын ЭМТ, соёлын төв, цэцэрлэг, Цээл сумын дунд сургууль, цэцэрлэг, соёлын төв, Есөнбулаг сумын 3-р сургууль, Уламжлалт Анагаах ухааны төв г.м
- 6.4.2-т заасан тухайн байгууллагын хууль, тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй.
- 6.4.3-т Тендер худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл: Бигэр, Бугат, Дэлгэр, Дарив, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цогт Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумууд нь тендер худалдан авах ажиллагаатай холбоотой тендерийн баримт бичиг, зар мэдээ, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг огт мэдээлээгүй байна. ТБОНӨХБАҮХ авах тухай хуулийн дагуу тухайн сумдад тендер зарлах боломжгүй босго үнээс давсан ХАА-г аймгийн ХААА зохион байгуулж тэдгээрийн мэдээллийг өөрийн цахим хуудаснаа мэдээлжээ.
- 6.4.5-д заасан Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ: Байгууллагуудын данс болон сангуудын хуулгыг авч

5.0 сая төгрөгөөс дээш 8,024.6 сая төгрөгийн 538 гүйлгээ гарснаас 6,314.7 сая төгрөгийн 351 гүйлгээг мэдээлж, 1,709.8 сая төгрөгийн 187 гүйлгээг мэдээлээгүй байна. Зарлагын гүйлгээг мэдээлэхдээ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10<sup>6</sup>-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх маягтыг бөглөөгүй, түүнийг мэдээлээгүй байна. Тухайлбал: Алтай сумын ЗДТГ 12 гүйлгээ, Чандмань ЗДТГ-1 гүйлгээ, Есөнбулаг сумын ЗДТГ-1 гүйлгээ, МСҮТ-3 гүйлгээ, Нийтлэг үйлчилгээ ОНТҮГ-1 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна.

- 6.4.6-д заасан худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн: 2015 онд аймгийн Аудитын газраас “Сургууль, цэцэрлэг, ЭМТ-ийн хүнсний материалын худалдан авалт зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, ҮАГ-ын захиалгаар сумдад хийгдсэн ОНХС-гийн зарцуулалтын байдалд хийсэн нийцлийн аудитын тайлан шийдвэр, дүгнэлтийг 99 байгууллага мэдээлээгүй байна. Үүнд: Бүх сумдын Сургууль, Цэцэрлэг, ЭМТ, ЗДТГ-ууд хамрагдаж байна.
- 6.4.7-д заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт: Дэлгэр сумын Гуулин тосгоны Дунд сургууль, Дэлгэр, Бугат, Алтай, Хөхморьт, Төгрөг сумдын ЗДТГ, Жаргалан сумын Дунд сургууль, Гаалийн хороо, Уламжлалт анагаах ухааны төв зэрэг байгууллагуудын батлагдсан орон тоонд өөрчлөлт орсон боловч түүнийг мэдээлээгүй байна.
- 6.4.8-д заасан байгууллагын даргын өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэхтэй холбоотой шийдвэр: Аудитад хамрагдсан байгууллагуудын тушаалыг шилэн дансанд мэдээлсэн тушаалтай тулган баталгаажуулахад мэдээлэх ёстой 2,150.3 сая төгрөгийн 1276 тушаал шийдвэрийг мэдээлэхээс 1,275.3 сая төгрөгийн 751 тушаал шийдвэрийг мэдээлж 875.5 сая төгрөгийн 499 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна. /хавсралт №4/
- 6.4.9-д заасан хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл: Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1<sup>5</sup>-д тодорхойлсон үзүүлэлт, хүрэх үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлтийг 7 байгууллага бүрэн мэдээлж, 23 байгууллага дутуу, 164 байгууллага огт мэдээлээгүй байна.

### **2.3 Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Сангийн яам бөгөөд энэ асуудлыг ҮАГ дээр авч үзнэ.**

### **2.4 Төрийн захиргааны байгууллагууд НДС-гаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг 57%-тай мэдээлжээ.**

Засгийн газрын 2014 оны 378-р тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.3<sup>7</sup>-т заасны дагуу НДС-гаас олгосон тэтгэвэр тэтгэмжийн талаарх мэдээллийг тухайн байгууллагууд мэдээлэх үүрэгтэй.

Аймгийн НДХ нь НДС-аас олгосон тэтгэвэр тэтгэмжийг шилэн дансанд зөрүүгүй мэдээлсэн байна. /хавсралт №4/

<sup>5</sup> Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.

<sup>6</sup> Эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт

<sup>7</sup> Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор хуулийн 6.1-д заасан байгууллага энэхүү журмын 16 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар мэдээлнэ

Аудитад хамрагдсан 199 байгууллагын дансны хуулгыг авч үзэхэд НДС-гаас 119 байгууллага 352.7 сая төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж, 13.4 сая төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авчээ.

Үүнээс: Жирэмсэн амаржсаны тэтгэмж 116 хүнтэй холбоотой 150.3 сая төгрөгийг мэдээлсэн, 105 хүнтэй холбоотой 202.4 сая төгрөгийг огт мэдээлээгүй байна.

Мөн 50 хүнтэй холбоотой 8,4 сая төгрөгийн ХЧТА-ы тэтгэмжийг мэдээлсэн боловч хугацаа нь тодорхой бус, 34 хүнтэй холбоотой 5,0 сая төгрөгийг мэдээлээгүй байна. /хавсралт№5/

## 2.5 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллага аймагт байхгүй.

## 2.6 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4-т заасан байгууллагууд 6.9-д заасан мэдээллийг мэдээлээгүй, хангалтгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн хөрөнгөөр 2015 онд 10.0 сая төгрөгөөс дээш 121 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлыг хийж гүйцэтгэсэн нийт 98 байгууллага, иргэдийн бүлгээс ААНБ, компани-56, ТББ-1, Хоршоо ба иргэдийн бүлэг-41 байна. Эдгээр хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг нийт 7,071.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр гүйцэтгэжээ. /хавсралт№6, 7/

### Хүснэгт №4: 10 сая төгрөгөөс дээш төсөл арга хэмжээний мэдээлэл

| Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээ ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа ААНБ /10 саяаас дээш/ | Хамрагдаж байгаа төсөл арга хэмжээний тоо | Мэдээлсэн эсэх / ААНБ-ын тоогоор/          |                                 |                 |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|--------------------------------------------|---------------------------------|-----------------|
|                                                                                                                                       |                                           | Эдгээрээс нэгдсэн цахим хуудсаар мэдээлсэн | Өөрийн цахим хуудсаар мэдээлсэн | Огт мэдээлээгүй |
| А. ААНБ, Компаний нэр                                                                                                                 | 76                                        | 0                                          | 1                               | 55              |
| Б. Төрийн бус байгууллага                                                                                                             | 1                                         | 0                                          | 0                               | 1               |
| В. Хоршоо, нэгдэл, иргэдийн бүлэг                                                                                                     | 44                                        | 0                                          | 0                               | 41              |
| Дүн                                                                                                                                   | 121                                       | 0                                          | 1                               | 97              |

Аймгийн хэмжээнд 10.0 сая төгрөгөөс дээш төсөл арга хэмжээ гүйцэтгэж байгаа 121 төсөл арга хэмжээг 98 ААНБ, хоршоо, иргэдийн бүлэг гүйцэтгэж байна. “Монголын цахилгаан холбоо” ХХК нь Жаргалан, Хөхморьт, Цогт, Цээл, Шарга сумдад интернетийн сүлжээ, шилэн кабелийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээтэй ажиллаж өөрийн цахим хуудсаар мэдээлсэн, 97 ААНБ, хоршоо, иргэдийн бүлэг 116 төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Бусад аж ахуйн нэгж нь хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байгаа нь шилэн дансны тухай хуулийн 6.9<sup>8</sup>-д заасан заалтыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ. Иймд улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл арга хэмжээ, ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдийг санхүүжилтээр нь хөшүүрэг болгон, гэрээ байгуулах явцдаа санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудас, мэдээллийн самбарт мэдээллээ заавал оруулах, дараа нь мэдээллээ оруулсан эсэхийг харгалзан тендерт оролцуулдаг байх шаардлагыг хууль журамд оруулж өгөх нь зүйтэй байна.

<sup>8</sup> Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээлэлийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас мэдээлэлийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно.

Мэдээлэлийг төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээлэлийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулахад энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд төлбөр төлөхгүй.

### **БҮЛЭГ 3. БҮХ ШАТНЫ ИТХ, БИНХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХГҮЙ БАЙНА.**

#### **3.1 Бүх шатны ИТХ, БИНХ-аас шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавихгүй байна.**

Хуулийн 8.1<sup>9</sup>-ийн хэрэгжилт:

- Шарга, Жаргалан сумдын ИТХ-аас бусад аймгийн ИТХ, сумдын ИТХ, багийн ИНХ хяналт тавьж ажиллаагүй байна. /хавсралт№8/
- Төрийн аудитын байгууллагын зүгээс Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөр” батлагдсаны дагуу шилэн дансны мэдээллийг аудит хийх бүртээ тогтмол хянах үүрэг чиглэл өгөгдсөн. Үүний дагуу 2015 онд аймгийн аудитын газраас 2015 оны 04, 07-р сард хуулийн хэрэгжилтэнд хяналт хийж, холбогдох албан тушаалтан, байгууллагад зөвлөмж өгч ажилласан байна.

#### **3.2 Санхүүгийн хяналт, аудитын алба нь шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж ажиллаж байна.**

Шилэн дансны тухай хуулийн 8.2<sup>10</sup>, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас явцын хяналт шалгалт хийж ажилласнаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь өссөн байна. Гэвч зарим байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарын хариуцлагагүй байдлаас мэдээлэл зөрүүтэй, дутуу байна.

#### **3.3 Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах тал дээр холбогдох газарт санал хүргүүлсэн боловч, шийдвэрлэгдээгүй байна.**

- Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар Бугат, Халиун сумдын ЗДТГ-ын дарга, Эрдэнэ сумын Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн эрхлэгчид хуулийн хэрэгжилт хангалтгүй тул хариуцлага тооцох санал хүргүүлж сануулах арга хэмжээ авчээ.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитаар 68 төсөл сан, хуулийн этгээд, мэдээллээ оруулаагүй байна гэжээ. Хэрэгжилтийг нэгж байгууллага тус бүрээр хянаж үзэхэд хангалтгүй байна. Тухайлбал: Эрдэнэ сумын Цэцэрлэг, ЭМТ, Сумдын ОНХС, Халиун сумын ОНХС, 6 сумын Төрийн сан, 2 сумын СХС, “Хантайшир Эрдэм цогцолбор” цэцэрлэг зэрэг байгууллагууд мэдээллээ оруулсан. Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа, “Нийтлэг үйлчилгээ” ОНӨҮГ-ууд нь мэдээллээ дутуу оруулжээ. Сумдын 16 СХС, Тагнуулын хэлтэс, “Дарив-Дулаан”, “Эрдэнэ-Эрчим”, “Орон сууцны алба”, “Зураг зүйн товчоо” зэрэг ОНӨААТҮГ-ууд, 12 сумдын төрийн сангууд, ЖДҮДТөв зэрэг нь мэдээллээ огт оруулаагүй байна.
- Мөн ОНХС, ЗГТС-гийн аудитаар аймгийн Засаг даргад 1 заалт зөвлөмжийг хүргүүлсэн байна.

<sup>9</sup> Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, иргэдийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

<sup>10</sup> Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

Шийдвэрийн хэрэгжилтийг нийтэд нь бодит байдал дээр үзэхэд 43%-тай байна. /хавсралт№9/

Шийдвэрийг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас Сангийн яам болон “Интерактив” ХХК-д цахим хуудсанд нэр нь ороогүй, давхардсан байгууллагыг нэмж хасах талаар албан тоотоор хүсэлт илгээсэн боловч бодит байдал дээр хэрэгжээгүй байна.

### **Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.**

Аудитаар нийт 5,775.8 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн 5,778.5 сая төгрөгийн зөрчилд 12 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 18 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 1 албан тушаалтанд 1 заалт бүхий зөвлөмж, ҮАГ-т 1 заалт саналыг холбогдох байгууллага болон албан тушаалтанд хүргүүллээ.

1. Шилэн дансны цахим хуудсанд 13 байгууллагын нэр нь илүү орсон, 4 байгууллагын нэр давхардсан
2. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл тавьсан огноо тодорхой бус, гар ажиллагаа ихтэй, буруу оруулсан мэдээллийг эргэж устгах боломжгүй, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийг сонгох хувилбарт тухайн сум орон нутгийн ААНБ, компани иргэдийн бүлгийн нэр байхгүй, мэдээлэл нэг цэсээс нөгөө цэсэнд татагдах боломжгүй, хуульд заасан бусад /СХС-гийн мэдээлэл, аудит дүгнэлт, санхүүгийн тайлан, төсвийн төсөл г.м/ мэдээллийг оруулах цэс байхгүй
3. Мэдээллүүдийн хоорондын уялдаа хангалтгүй, иргэн бүрэн цогц мэдээлэл авах боломж бага байгаагаас мэдээллээ тавиагүй байна гэсэн асуудал үүсч мэдээллийн ач холбогдол буурч байна. Мөн байгууллагын цэс, нэгдсэн цахим хуудсыг хооронд нь холбох боломж байхгүйгээс мэдээлэл тавих ажилтны ажлын ачаалал ихтэй байна.
4. Байгууллагуудын данс болон сангуудын хуулгыг авч 5.0 сая төгрөгөөс дээш 8,024.6 сая төгрөгийн 538 гүйлгээ гарснаас 6,314.7 сая төгрөгийн 351 гүйлгээг мэдээлж, 1,709.8 сая төгрөгийн 187 гүйлгээг мэдээлээгүй байна.
5. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг 9 байгууллага мэдээлээгүй байна
6. Аудитад хамрагдсан байгууллагуудын тушаалыг шилэн дансанд мэдээлсэн шийдвэртэй тулган баталгаажуулахад 2,150.3 сая төгрөгийн 1270 шийдвэрийг мэдээлэхээс 1,275.3 сая төгрөгийн 751 тушаал шийдвэрийг мэдээлж, 875.5 сая төгрөгийн 499 тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.
7. ОНХС-гийн гүйцэтгэл 3-р улирлын байдлаар 3,956.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гарснаас 3,680.1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус , 769.0 сая төгрөгийн гүйлгээг орхигдуулсан , 492.3 сая төгрөгийн гүйлгээг илүү мэдээлсэн байна
8. Төсөвт байгууллагуудын тухайн жилийн төсвийг 1,481.9 сая төгрөгөөр дутуу, 28.5 сая төгрөгөөр илүү мэдээлсэн, төсвийн гүйцэтгэлийг 3-р улирлын байдлаар 834.2 сая төгрөгөөр дутуу, 504.0 сая төгрөгөөр илүү мэдээлсэн байна
9. Байгууллагуудын 3-р улирлын байдлаархи төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн зардлын дүн 3,494.2 сая төгрөг байгаагаас 1,385.2 сая төгрөгийн хэмнэсэн зардлын тайлбарыг оновчгүй ба огт бичээгүй байна
10. Жирэмсэн амарсаны тэтгэмж 116 хүнтэй холбоотой 150.3 сая төгрөгийг мэдээлсэн, 105 хүнтэй холбоотой 202.4 сая төгрөгийн, хөдөлмөрийн чадвараа



түр алдсаны тэтгэмж 50 хүнтэй холбоотой 8.4 сая төгрөгийг мэдээлсэн боловч хугацаа тодорхой бус, 31 хүнтэй холбоотой 5.0 сая төгрөгийг мэдээлээгүй байна.

11. Аймгийн хэмжээнд 10.0 сая төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнээс өөрийн цахим хуудсаар мэдээлсэн 1, огт мэдээлээгүй 97 ААНБ, хоршоо, иргэдийн бүлэг байна.
12. Аймгийн аудитын газраас “Сургууль цэцэрлэг,ЭМТ-ийн хүнсний материалын худалдан авалт зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан,ҮАГ-ын захиалгаар сумдад хийгдсэн “ОНХС-гийн зарцуулалт”-ын байдалд хийсэн нийцлийн аудитын тайлан, шийдвэр, дүгнэлтийг 99 байгууллага мэдээлээгүй байна
13. Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 6.2.1 -д тодорхойлсон үзүүлэлтэд хүрэх үр дүн тоон болон чанарын үзүүлэлтийг 164 байгууллага огт мэдээлээгүй,7 байгууллага мэдээлсэн, 23 байгууллага дутуу мэдээлсэн байна.
14. Шарга, Жаргалан сумдаас бусад бүх шатны ИТХ,БИНХ-аас шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна
15. Өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох газарт санал хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна
16. Шилэн дансны цахим хуудсан Монгол Элсний Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргаа нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-6.1.4-т заасан мэдээлэл, 6.4.1-6.4.6-д заасан мэдээллүүдийг оруулаагүй.
17. Бигэр, Бугат, Жаргалан сумдын төсөвт байгууллагууд нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-6.1.4-т заасан мэдээлэл, 6.4.1-6.4.6-д заасан мэдээллүүдийг оруулаагүй, хэрэгжилтийг хангуулж ажиллах тал дээр санаачлагагүй ажилласан байна.
18. Бигэр, Гуулин, Баянтоорой тосгоны захирагчийн алба нь төсөв гүйцэтгэлээс өөр мэдээлэл оруулаагүй, “Орон сууцны алба” ОНӨААТҮГ, “Барилгын зураг төсвийн товчоо” ОНӨААТҮГ, Ахмадын хороо нь ямар ч мэдээлэл оруулаагүй байна.
19. Бигэр, Бугат сумдын дунд сургууль, Тахийн талын бага сургууль, Бигэр, Бугат, Жаргалан сумын Хүүхдийн цэцэрлэг, Цогт сумын Баянтоорой тосгоны Хүүхдийн цэцэрлэг нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-6.1.4-т заасан мэдээлэл, 6.4.1-6.4.6-д заасан мэдээллүүдийг оруулаагүй, удаа дараа холбогдох байгууллагаас шаардлага тавьсан боловч биелүүлээгүй байна.
20. Бигэр, Бугат сумын Соёлын төв, ЭМТ, Цогт сумын Баянтоорой тосгоны Соёлын төв, ЭМТ-үүд нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-6.1.4-т заасан мэдээлэл, 6.4.1-6.4.6-д заасан мэдээллүүдийг оруулаагүй, удаа дараа холбогдох байгууллагаас шаардлага тавьсан боловч биелүүлээгүй байна.



Жич: Аймгийн Засаг даргын 2015 оны 10 сарын 28-ны өдрийн 1/1476 тоот албан бичгээр Бугат сумын ЭМТ, Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэг, Жаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт хуулийн дагуу арга хэмжээ тооцсон тул эдгээр байгууллагыг хариуцлага тооцох албан шаардлагаас хассан болно.

### **ДҮГНЭЛТ**

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АРВАН САЯ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ МЭДЭЭЛЭЭГҮЙ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД БҮХ ШАТНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ ХЯНАЛТ ТАВИАГҮЙГ ЭС ТООЦВОЛ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖИЖ БАЙНА.

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

**Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэр гаргаж байна.**

**Санал**

**Үндэсний аудитын газрын харьяа Нийцлийн аудитын газарт:**

1. Шилэн дансны цахим хуудсанд нэр нь илүү орсон, давхардсан байгууллагуудын нэрийг хасч, шилэн дансны цахим хуудсанд хандсан хугацаагаар хяналт тавих боломжтой, боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллах

**Зөвлөмж**

**Аймаг, Сумдын ИТХ-ийн дарга нарт:**

1. Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн шилэн дансны үйл ажиллагаа, хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах

**Албан шаардлага**

**Зөрчил арилгуулах албан шаардлага**

**Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт**

1. Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл арга хэмжээ, ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах заалт оруулж мэдээллээ оруулсан эсэхийг харгалзан санхүүжилтийг олгох, дараагийн ХАА-нд оролцоход шалгуур үзүүлэлт болгож өгөх
2. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллан, түүнд хяналт тавьж ажиллах.

**Хариуцлага тооцох албан шаардлага**

**БОНХАЖАаманд**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн Монгол элсний Улсын тусгай хамгаалттай газар нутгийн захиргааны дарга Х.Баттулга, Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргааны дарга Л.Төвд нарт холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох

**Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт**

1. Хуульд заасан мэдээллийг оруулаагүй Бугат сумын Засаг дарга А.Мягмаршагдар, Бигэр сумын Засаг дарга Ж.Энхтүвшин, Жаргалан сумын Засаг дарга А.Пүрэвсүрэн нарт хуулийн дагуу хариуцлага тооцох
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ын дарга С.Эрдэнэ-Очир, “Барилгын зураг төсвийн товчоо” ОНӨААТҮГ-ын дарга Б.Бямбадорж, Ахмадын хорооны дарга Ч.Галсанчоймбол нарт холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох

**Боловсролын газрын даргад**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн Бигэр сумын дунд сургуулийн захирал Т.Үйтүмэн, Тахийн талын бага сургуулийн захирал Л.Билэгдэмбэрэл, Бигэр сумын цэцэрлэгийн эрхлэгч Б.Нэргүй, Цогт сумын Баянтоорой тосгоны хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Батчулуун нарт холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох

**Бигэр сумын Засаг дарга Ж.Энхтүвшинд**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн Бигэр сумын соёлын төвийн эрхлэгч Л.Сувданцэцэг, ЭМТ-ийн эрхлэгч Р.Сарантуяа нарт холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох

**Цогт сумын Засаг дарга нарт**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн Баянтоорой тосгоны соёлын төвийн эрхлэгч Д.Энхчимэг, ЭМТ-ийн эрхлэгч Ж.Одгэрэл нарт хариуцлага тооцох

**Дэлгэр сумын Засаг дарга Н.Наянбууд**

1. Шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн Дэлгэр сумын Гуулин тосгоны захирагч Б.Төвшинзаяад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох

**Цогт сумын Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Т.Сүхбаатарт**

1. Шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн Цогт сумын Баянтоорой тосгоны захирагч Д.Лхагвасүрэнд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох

## Холбогдох байгууллагын санал

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА82091 Харзат, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг,  
Утас: 7048-4004, Факс: (976) 7048-3380

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2015.12.01 № 1/1681  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -тШилэн дансны хуулийн хэрэгжилтийн  
тухай

Тус аймагт шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын дагуу Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба тасралтгүй хяналт тавьж, хуулийн хүрээнд хамаарагдах төсвийн, төрийн болон орон нутгийн өмчид байгууллагуудад заавар зөвлөгөө өгч байна.

Тус алба нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах талаар сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга, Санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч нарт болон аймгийн төвийн төсөвт байгууллагуудад 5 удаагийн сургалтыг Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран зохион байгуулж, мэдээллээр ханган ажиллаж байна.

Нэгдсэн цахим хуудсанд давхар бүртгэгдсэн, татан буугдсан байгууллагуудын нэрсийг үндэсний ДАТА төвөөр хасуулсан бөгөөд хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зөрчил гаргасан хуулийн этгээд, албан тушаалтнуудад хариуцлага ногдуулан ажиллаж, улсын болон орон нутгийн радио телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилж байна.

Тус хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй сумын Засаг дарга, төсвийн шууд захирагч нарт 2016 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ болон үр дүнгийн гэрээг дүгнэхдээ холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулахаар шийдвэрлэсэн болно.

Нийцлийн аудитын тайланд дурдсан 2316,1 сая төгрөгийг дутуу мэдээлсэн гэсэн зөрчлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Учир нь Шилэн дансны тухай хуулийн 5.7, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.5 дахь заалтуудын дагуу цахим хуудасны шилэн данс цэсэнд аймгийн ИТХ-ын 2015 оны 02 дугаар тогтоол <http://www.govi-altai.gov.mn/blog/read/1149>, ИТХ-ын 2015 оны 05 дугаар <http://www.govi-altai.gov.mn/blog/read/1234> тогтоолуудаар батлагдсан төсвийн тодотголыг бүрэн эхээр нь байршуулснаас гадна төсөвт байгууллагууд ил тод байдлын самбарт төсвийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээ тогтмол мэдээлж хэвшүүлсэн болно.

Цаашид ажил сайжруулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг зохион байгуулж 12 дугаар сарын 25-ны дотор хариу албан бичгээр мэдэгдэх болно.

Тайлан дүгнэлттэй санал нэг байна.

О.АМГАЛАНБААТАР

n2 n1838

## Хариу тайлбар

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд”-д хийсэн нийцлийн аудиттай холбогдох байгууллага танилцаж санал ирүүлсэнд дараах хариу тайлбар хүргүүлж байна.

| д/д                   | Байгууллагын ирүүлсэн санал                                                                                                     | Хариу тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|-----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Санал хүргүүлэх тухай |                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| 1                     | “Нийцлийн аудитын тайланд дурдсан 2,316.1 сая төгрөгийг дутуу мэдээлсэн гэсэн зөрчлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна” гэжээ. | <p>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт /Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 7 хоногийн дотор мэдээлнэ/ гэж заасан. Гэтэл нэр бүхий байгууллагууд төсөвт орсон өөрчлөлтийг мэдээлээгүй буюу зөрүүтэй мэдээлснээс 1,481.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.</p> <p>Мөн шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт/ сар улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны дотор тогтмол мэдээлнэ/ гэж заасан. Гэтэл тухайн байгууллагуудын дансны хуулгаар гарсан цэвэр төсвийг шилэн дансанд мэдээлсэн төсвийн гүйцэтгэлтэй харьцуулан харахад 834.2 сая төгрөгийн зардлыг огт шивээгүй орхигдуулсан байсан. Эдгээрх 2,316.1 мянган төгрөгийн зөрчлийг тайлангаас хасалгүй төлбөр зөрчлийн мөнгөн дүнгээс хасан тооцож, саналыг хүлээн авлаа.</p> |